



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар A/67

Биндэр сум

Сумын алдарт уяач цол олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын үндэсний баяр наадмын хурдан морины уралдаанд амжилт гаргаж хуульд заасан болзол шаардлагыг хангасан Баян-Өндөр багийн иргэн Пүрэвийн Чинзориг, Мандалхаан багийн иргэн Наранмижидийн Бат-Эрдэнэ, Дэлгэрхаан багийн иргэн Жаргалсайханы Энхбат нарт "Сумын алдарт уяач" цол олгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАСАГ ЗАХИРГАА
НУТАГ ДЭВСГЭРИЙН
НЭГЖ